

## НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

**Товч удирдамж:** Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн дор /ард/ хариултаа үнэн зөв, бүрэн дүүрэн бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралтыг Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ. Мөн, нэр дэвших тухай хүсэлтийг Word-ын файлаар цахим шуудан /сонгон шалгаруулах тухай зард заасан хаяг/-аар тус байнгын хороонд явуулна.

### НЭГ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

1.1	<b>Эцэг/эхийн нэр:</b> Базаррагчаа <b>Ургийн овог:</b> Боржигон <b>Нэр:</b> Даваажав <b>Хүйс:</b> Эрэгтэй <b>Төрсөн он:</b> 1985 <b>Төрсөн газар:</b> Улаанбаатар хот, 1 дүгээр амаржих газар <b>Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг:</b> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, [REDACTED]
1.2	<b>Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал</b> Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүний аль нэгийг бичнэ. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн шүүгч бус гишүүн
1.3	<b>Иргэний харьяалал</b> Монгол Улсын иргэн мөн үү /тийм эсхүл үгүй гэж бичих/. Тийм
1.4	<b>Насны дээр хязгаар</b> Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үү /тийм эсхүл үгүй гэж бичих/. Үгүй
1.5	<b>Улс төрийн болон намын удирдах албан тушаал</b> Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. Үгүй
1.6	<b>Шүүгчийн албан тушаал</b> Үгүй
1.7	<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн</b> Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.

	Үгүй
<b>1.8</b>	<p><b>Шүүхийн сахилгын хорооны гишүүн</b> Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p>
	Үгүй
<b>1.9</b>	<p><b>Шүүхийн захиргааны байгууллагын ажилтан</b> Шүүхийн захиргааны байгууллагын ажилтны ажил, албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг ажил, албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p>
	Үгүй
<b>1.10</b>	<p><b>Хуульч</b> Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй юу, эсхүл ийм зөвшөөрөлтэй байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг зөвшөөрлийг ямар хугацаанд эзэмшиж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p>
	<p>Тийм</p> <ol style="list-style-type: none"> <li>2014 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Монголын хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн тушаалаар Монголын хуульчдын холбооны гишүүнээр элсүүлсэн учир 3884 дугаар бүхий Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээг олгосон.</li> <li>2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль шинээр үйлчилж эхэлж байгаатай холбогдуулан Монгол Улсын Хууль зүйн сайдын 2013 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/163 дугаар тушаалаар хуульчдын нэгдсэн бүртгэлийн 5575 дугаарт бүртгэгдсэн.</li> <li>2012 оны Хуульчдын сонгон шалгаруулалтад тэндсэн учир 2012 оны 09 дүгээр сарын 19-ны өдөр 0005575 дугаартай гэрчилгээ олгогдсон. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг 10 дахь жилдээ явуулж байна.</li> </ol>
<b>1.11</b>	<p><b>Өмгөөлөгч</b> Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй юу, эсхүл ийм эрхтэй байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг эрхийг ямар хугацаанд эдэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p>
	<p>Тийм</p> <ul style="list-style-type: none"> <li>2013 оны 11 дүгээр сарын 01-ны өдөр Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу Улсын Дээд шүүхээс шүүхэд төлөөлөх эрх нээлгэх хүсэлтийг хүлээн авч 131351 дугаартай Өмгөөлөгчийн Шүүхэд төлөөлөх эрхийн гэрчилгээ олгогдсон. Өмгөөллийн үйл ажиллагааг 13 дахь жилдээ явуулж байна.</li> </ul>
<b>1.12</b>	<p><b>Прокурор</b> Прокурорын албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p>
	Үгүй
<b>1.13</b>	<p><b>Эрүүгийн хариуцлага</b> Эрүүгийн хариуцлага хүлээж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн</p>

	сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	Үгүй
<b>1.14</b>	<b>Сахилгын шийтгэл</b> Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	Үгүй

## ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

<b>2.1</b>	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны гишүүний хувьд хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /энэ хоёр албан тушаалын аль нэг орон тоог нь сонгож, тайлбарыг 500-1000 үгэнд багтаана/</p> <p><b>Шүүхийн Ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшсэн үндэслэл, хийх ажлын тайлбар:</b></p> <p>Монгол Улсын Үндсэн хуульд заасан шүүхийн бие даасан, хараат бус, ил тод, хариуцлагатай тогтолцоог бүрдүүлэх нь нийгмийн тогтвортой байдал, иргэдийн хуульд итгэх итгэлийг хадгалах үндэс болдог. Шүүхийн ерөнхий зөвлөл бол энэ тогтолцооны төв цөм, хариуцлагын эзэн байх учиртай шүүхийн захиргааны байгууллага юм.</p> <p>Хуульч-Өмгөөлөгч, багш хүний хувьд олон жилийн турш шүүхийн үйл ажиллагааг хөндлөнгөөс ажиглаж, оролцож, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, зарим үед шүүмжилж, зарим үед хамгаалж ирсэн хүний хувьд өнөөгийн шүүхийн тогтолцоонд тулгамдаж буй бодлогын болон байгууллагын олон асуудлыг бодитоор мэдэрч, судалж ирлээ. Надад нэр дэвших шийдвэр гаргах болсон үндсэн шалтгаан бол шүүхийг хуулийн болоод итгэл үнэмшлийн хүчээр хамгаалж, шинэчлэх хүсэл, зориг юм. Миний зорилго бол системийн шүүмжлэлээс системийн шинэчлэл рүү зоригтой алхах алхмыг эхлүүлэх явдал юм. Түүнчлэн шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших болсон миний зорилго, эрхэм зорилт нь хэд хэдэн үндэслэлд тулгуурлаж байна.</p> <p><b>Нэгдүгээрт:</b> Өнөөгийн шүүхийн тогтолцоо нь хууль зүйн үндэслэлтэй боловч бодит байдал дээрээ иргэдийн итгэлийг хангаж чадахгүй хэмжээнд байгаа нь үнэн. Шүүхийн шийдвэрийн ойлгомжгүй байдал, шүүгчийн ёс зүйн зөрчил, нэр дэвшүүлэлт ба томилгооны үйл явц дахь ил тод бус аргууд зэрэг нь ард иргэдийн шүүхэд хандах хандлагад сөргөөр нөлөөлж байна.</p> <p><b>Хоёрдугаарт:</b> Шүүгчийн хараат бус байдлыг хангах нэрийн дор зарим тохиолдолд хариуцлагаас зайлсхийх, хэт төвлөрсөн тогтолцоог хамгаалах үзэгдэл дэлгэрч байгаа нь шүүхийн засаглалыг төрийн бусад эрх мэдлийн хяналтаас тусгаарлах бус, харин нийгмийн итгэлцлээс тасалдуулах нөхцөл болж байна. Шүүгч бол хуульд захирагддаг иргэн. Тэрхүү иргэний шалгуур, сургалт, ёс зүй, сахилга хариуцлагын тогтолцоог төгөлдөржүүлэх шаардлагатай байна.</p> <p><b>Гуравдугаарт:</b> Би өмгөөлөгчийн хувьд иргэдийн шүүхээр дамжуулан хууль, эрх зүйн маргаанаа шийдвэрлүүлэх эрхийг хамгаалах үүднээс олон зуун хэрэгт оролцож, оновчтой, шударга шийдвэрийн төлөө тэмцэж ирсэн. Энэ туршлагаас харахад шүүхийн дотоод зохион байгуулалт, шүүгчийн ёс зүй, маргааныг хянах хэм хэмжээ, хүртээмж, үйлчилгээний чанарт тодорхой шинэчлэл шаардлагатай байна.</p> <p>Иймд миний бие дээр дурьдсан үндэслэлүүдэд тулгуурлан дараах чиглэлүүдэд анхаарч, бодлогын тодорхой зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:</p>
------------	---

## **Нэг. Шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлэх бодлого**

Шүүхийн бие даасан байдал гэдэг нь зөвхөн гадаад оролцооноос хамгаалах асуудал биш. Энэ бол шүүх өөрийн дотоод үнэт зүйл, үйл ажиллагааны зарчим, ёс суртахуун, мэргэжлийн өндөр хариуцлага дээр тулгуурлан хараат бус, шударга, итгэл төрүүлсэн байдлаар ажиллах чадамжийг илэрхийлдэг ойлголт юм.

### **1. Шүүхийн институцийн баталгааг бэхжүүлэх:**

Шүүхийн төсвийн хараат бус байдал, хүний нөөцийн чөлөөтэй бодлого, дотоод зохион байгуулалтын бие даасан байдлыг бодитой хэрэгжүүлж чадаагүй тохиолдолд шүүгчийн хараат бус байдал амьдрал дээр хэрэгжих боломжгүй юм. Иймд Шүүхийн ерөнхий зөвлөл нь зөвхөн хянагч, зохицуулагч биш, харин шүүхийн институцийн бодлогын хамгаалагч байх ёстой.

### **2. Шүүгчийг нөлөөллөөс ангид байлгах механизм бүрдүүлэх:**

Шүүгчийн хараат бус байдлыг хуулиар баталгаажуулах нь хангалтгүй. Тэдний мэргэжлийн хамгаалалт, нийгмийн баталгаа, халдашгүй байдал, хараат бус шийдвэр гаргах сэтгэлзүйн орчныг бүрдүүлэхэд илүүтэй анхаарах ёстой. Үүнд:

- Шүүгчийн халдашгүй байдлын хамгаалалтыг бодитой хэрэгжүүлэх
- Нөлөөлөл үзүүлэх оролдлогын эсрэг онцгой хамгаалалт бий болгох

### **3. Олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх:**

Шүүх хараат бус байх ёстой. Гэвч шүүх нийгмээс тусгаарлагдах ёсгүй. Олон нийтийн итгэлцэл бол шүүхийн хамгийн том баталгаа. Иймд:

- Шүүхийн шийдвэрийн ил тод байдал
- Иргэдэд ойлгомжтой шийдвэр бичих стандарт
- Олон нийттэй харилцах, тайлагнах бодлого гэсэн гурван чиглэлийн шинэчлэл хийхийг зорьж ажиллах болно.

## **Хоёр. Шүүгчийг сонгон шалгаруулах тогтолцооны шинэчлэл**

Шүүгчийн нэр хүнд бол шүүхийн нэр хүнд юм. Иймд шүүгчийг сонгон шалгаруулах, дэвшүүлэх, томилох тогтолцоо нь туйлын ил тод, шударга, бодитой, олон нийтийн итгэлийг хүлээсэн байхаас шүүхийн ирээдүй шалтгаална. Өнөөдөр энэхүү тогтолцоонд ил тод бус, нууцлаг, зарим тохиолдолд ашиг сонирхлын зөрчил бүхий шийдвэрүүд нөлөөлдөг нь нийгмийн бухимдлыг төрүүлж буй.

### **1. Ил тод, олон нийтэд нээлттэй систем хэрэгжүүлэх**

Шүүгчид нэр дэвшигчийн боловсрол, туршлага, ёс зүйн түүх, өмгөөлөгчийн буюу прокурорын туршлага, нийгмийн хандлага, үзэл бодол зэрэг бүхий л үзүүлэлт ил тод байх ёстой. Үнэлгээний шалгуур нь тодорхой, нээлттэй, олон нийтээр хянагдах боломжтой, мэргэшилд суурилсан байх нь чухал.

### **2. Сонгон шалгаруулалтын комиссын хараат бус байдлыг хангах**

Одоогийн системд комиссын бүрэлдэхүүн, үйл ажиллагаа нь албаны түвшинд төвлөрсөн, бодлогын оролцоо хязгаарлагдмал байдалтай байна. Үүнийг шинэчлэн, академик, мэргэжлийн байгууллагууд, иргэний нийгмийн төлөөлөл бүхий олон талын төлөөлөлтэй болгох нь зохистой.

### 3. Шүүгчийг шатлан дэвшүүлэх, үнэлэх шалгуур шинэчлэх

Шүүгчийг мэргэжлийн ур чадвар, шийдвэрийн чанар, хурд, ёс зүйн байдал, иргэдийн үнэлгээ зэрэг олон шалгуураар тогтмол үнэлж, ил тод тайлагнадаг болох ёстой. Энэ нь зөвхөн урамшуулалд бус, дэвшүүлэлтэд шууд нөлөөлөх чадамжтай байх шаардлагатай.

### 4. Орон нутгийн тэгш төлөөллийг хангах бодлого

Шүүгчид зөвхөн төвлөрсөн буюу нийслэлд төвлөрдөг бус, орон нутгийн шүүхийн хүний нөөцийг чадваржуулах, тэгш боломжийг олгох бодлого чухал байна. Хөдөө орон нутгаас мэргэшсэн хуульчид шүүгчийн албан тушаалд өрсөлдөх, дэвших боломжоор хангагдсан байх ёстой.

### **Гурав. Шүүгчийн сургалт, хөгжлийн бодлого**

Шүүгч бол зөвхөн хууль мэддэг хүн биш, харин хүмүүнлэг, ёс суртахуунтай, нийгмийн толь, үнэт зүйлийг тээгч хүн байх учиртай. Энэ утгаараа шүүгчийн сургалт, тасралтгүй хөгжлийн бодлого бол зөвхөн мэдлэг нэмэх бус, төлөвшил, хандлага, ёс суртахууны боловсролд чиглэх ёстой.

#### 1. Сургалтын тогтолцоог шинэ шатанд гаргах

Шүүгчийн мэргэжлийн сургалтыг дан ганц хууль эрх зүйд бус, социологи, сэтгэл судлал, ёс зүй, бичгийн ур чадвар, олон нийттэй харилцах харилцаа, мэдээллийн технологи зэрэг чиглэлд цогцоор нь хамарсан агуулгаар хөгжүүлэх хэрэгтэй.

#### 2. Олон улсын туршлага, солилцоог өргөжүүлэх

Шүүгчийн сургалтыг гадаадын ижил байгууллага, их сургуулиудтай хамтран зохион байгуулах, олон улсын кейсүүд дээр суурилсан хичээлүүд, мастер класс, богино хугацааны хөтөлбөрүүдэд хамруулах бодлогыг дэмжинэ.

#### 3. Шүүгчийн тасралтгүй үнэлгээ ба сургалтын уялдаа

Шүүгчийг зөвхөн сургалтад хамруулах бус, сургалтын үр дүнг бодит үнэлгээтэй уялдуулж, хөгжлийн төлөвлөгөө гарган ажиллах систем нэвтрүүлнэ. Үр дүнгүй сургалт нь нөөцийн үрэлгэн зарцуулалт болдог учир чанарт төвлөрсөн шинэчлэл хэрэгтэй.

#### 4. Ёс зүйн боловсролыг тэргүүлэх чиглэл болгох

Сүүлийн жилүүдэд шүүгчдийн ёс зүйн зөрчилтэй холбоотой шүүмжлэл ихэссэн. Ёс зүйн зөрчил бол хууль зөрчсөн үйлдэл гэхээсээ өмнө хандлагын доголдол байдаг. Тиймээс шүүгчийн сонгон шалгаруулалтын шатнаас эхлэн тасралтгүй сургалт, ёс зүйн төлөвшилд анхаарах нь чухал.

### **Дөрөв. Шүүх хуралдааны зохион байгуулалт ба орчин нөхцөл**

Шүүх хуралдаан бол ардчиллын бодит талбар, иргэдийн хуулийн өмнөх эрхээ эдэлдэг гол процесс юм. Харамсалтай нь өнөөдөр шүүх хуралдааны зохион байгуулалт, танхимын орчин, техник хэрэгсэл, үйлчилгээнээс шалтгаалан шүүхэд хандах иргэдийн сэтгэл ханамж сул хэвээр байна.

### 1. Танхимын орчны стандарт шинэчлэх

Хуралдааны танхимуудын орчин хаа сайгүй ялгаатай, зарим нь үнэхээр тааруу нөхцөлтэй байгаа нь шүүхийн нэр хүндэд сөрөг нөлөөтэй. Хүний эрхийг дээдэлсэн, зохистой орчин, дуу бичлэгийн систем, камерын зохицуулалт, олон нийтэд нээлттэй сэтгэл зүйн тайван орчинг бүрдүүлэх нь зайлшгүй.

### 2. Дижитал шүүх хуралдааны дэд бүтцийг бүрдүүлэх

Цахим хуралдааны системийн хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн иргэд, гадаадад байгаа этгээдүүдийн оролцоог хангах, протокол хөтлөлт, шүүх хуралдааны бичлэгийн хадгалалт, түгээлтийг дижитал системд бүрэн шилжүүлэх шаардлагатай.

### 3. Хэрэглэгчийн үйлчилгээний төвтэй болох

Шүүх бол үйлчилгээний байгууллага. Иргэд анх орж ирэхээс шийдвэр гарсан хүртэл бүх үйл явцыг ойлгомжтой, тайлбарласан, энгийн хэлээр хүргэдэг, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөг нэг дороос авах боломжтой үйлчилгээний нэгжтэй байх шаардлагатай. Шүүхийн дэргэд “Иргэн төвтэй үйлчилгээний төв” байгуулна.

### 4. Хурдан шуурхай ажиллагааны шинэ стандарт хэрэгжүүлэх

Шүүх хуралдаан хугацаандаа эхлэхгүй, шүүгч хуралдаанд бэлэн биш, материал дутуу, орчуулагч ирээгүй гэх мэт хүндрэлүүд шүүх хуралдааны нэр хүндийг унагадаг. Үүнийг сайжруулах зорилгоор шүүх хуралдааны зохион байгуулалтад ISO стандарт нэвтрүүлж, хариуцлагын нарийн систем бий болгоно.

### **Тав. Ил тод байдал ба хариуцлагын шинэ механизм**

Шүүх бол хаалттай байгууллага байж болохгүй. Шүүхийн шийдвэр, үйл ажиллагаа, шүүгчдийн ёс зүйн байдал, гомдол хяналтын тогтолцоо зэрэг нь олон нийтийн нээлттэй хяналтад байж иргэдийн шүүхэд итгэх итгэл жинхэнэ утгаараа сэргэнэ. Иймд ил тод байдлыг хангах шинэ механизмуудыг хэрэгжүүлэх нь миний нэр дэвшиж буй үндэслэл, зорилтуудын чухал хэсэг юм.

#### 1. Шүүхийн шийдвэрийн чанар, статистик, гүйцэтгэлийн үнэлгээг нийтэд мэдээлдэг болгох

Шүүх бүр өөрийн гаргасан шийдвэрүүдийн тоо, чанарын үзүүлэлт, шийдвэрлэгдэх хугацаа, гомдолтой холбоотой мэдээллийг улирал тутамд олон нийтэд нээлттэй тайлагнаж байх шаардлагатай. Энэ нь шүүхийн ажил хэр үр дүнтэй явагдаж буйг иргэд хянах боломжоор хангах юм.

#### 2. Иргэдийн оролцоотой шүүхийн зөвлөлдөх хяналт бий болгох

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэд иргэд, хуульчид, эрдэмтэд, олон нийтийн төлөөллөөс бүрдсэн зөвлөлдөх зөвлөл байгуулж, шүүхийн бодлого, шүүгчийн мэргэжлийн үнэлгээ, ёс зүйн стандартын талаар санал авч, шийдвэр гаргах үйл явцад оролцуулна. Энэ нь шүүх нийгмээс тасарсан хаалттай байгууллага биш гэдгийг харуулах алхам болно.

	<p>3. Хяналт-шалгалтын үйл ажиллагааг цахимд бүрэн шилжүүлж, тайлагнах</p> <p>Шүүхийн дотоод хяналт, гүйцэтгэлийн шалгалт, сахилгын арга хэмжээний мэдээлэл, түүний үр дүнг нээлттэй, олон нийтэд ойлгомжтой байдлаар мэдээлдэг цахим системд бүрэн шилжүүлнэ. Хяналт нь хаалттай, дотоодын асуудал биш, иргэдийн мэдэх эрхийн нэг хэсэг байх ёстой.</p> <p>4. Шүүгчийн хөрөнгө, орлогын ил тод байдлыг хянах тогтолцоог боловсронгуй болгох</p> <p>Шүүгчийн өмч хөрөнгө, орлого, зээлийн мэдээллийг ил тод болгож, ашиг сонирхлын зөрчлийг илрүүлдэг, хөндлөнгийн хяналт бүхий цахим систем хөгжүүлнэ. Үүнийг АТГ, Шүүхийн ерөнхий зөвлөл, Иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаатайгаар хэрэгжүүлэх боломжтой.</p> <p>VI. Дүгнэлт:</p> <p>Өнөөдөр Монгол Улсад хууль дээдлэх зарчим суларч, иргэд шүүхийн шийдвэрт итгэх итгэл сул байна. Гэвч шүүх бол шударга ёсны хамгийн сүүлчийн найдвар. Шүүхийн тогтолцоог зөв бүтэц, зөв ёс суртахуун, зөв бодлогын системээр дахин төлөвлөх цаг ирээд байна.</p> <p>Өмгөөлөгч миний бие, нэр бүхий тодорхой бүлгийн эрх ашгийг бус, олон нийтийн нийтлэг эрх ашгийн төлөө, шударга ёсыг амьдралд хэрэгжүүлэхийн төлөө, шүүхийн шинэ үеийн бодлого хэрэгжүүлэхийн төлөө Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшиж байна.</p> <p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн бол зөвхөн мэргэжлийн албан тушаал биш, энэ бол үнэт зүйл, ёс суртахуун, шударга ёсны төлөө сэтгэлтэй, зоригтой хүний үүрэг, хариуцлага юм.</p> <p>Иймд би өөрийн мэдлэг, туршлага, итгэл үнэмшил дээр тулгуурлан шүүхийн тогтолцоонд бодитой хувь нэмэр оруулж, Монголын ард иргэдийн шударга шүүхэд итгэх итгэлийг сэргээхийн төлөө ажиллах болно.</p>
--	---

## ГУРАВ. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
3.1	<p><b>Боловсрол</b></p> <p>Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Монгол Улсын Дотоод хэргийн Их сургууль /2021-2023/ докторантурын сургалтанд хамрагдсан.</li> <li>2. Монгол Улсын Цагдаагийн Академийн магистрантур /2008-2010/ Хууль зүйн магистр LL.M. Диломын дугаар: E20103090</li> <li>3. Монгол Улсын Цагдаагийн Академи /2004-2008/ Эрх зүйч, бакалавр LL.B. Диломын дугаар: D200826730</li> </ol>
3.2	<p><b>Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал</b></p> <p>Хүсэлт гарагч нь эрх зүйч мэргэжлээр ажилласан ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар тодорхойлон бичих бөгөөд ажил тус бүрийг эрхэлж байсныг нотлох баримтыг хавсаргана. Ажил тус бүрийг тодорхойлохдоо дараах мэдээллийг заавал бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;</li> <li>-ажлын байрны тодорхойлолтын гол агуулга;</li> <li>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;</li> </ul>

	<p>-тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан таваас доошгүй хүний нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/.</p>
	<p>2020 оноос Өмгөөллийн “Дигест” ХХК-ийн гүйцэтгэх захирал, өмгөөлөгч, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо Монре Импексийн байр 709 тоот, Холбоо барих утасны дугаар: [REDACTED]. /Б.Цэнд-Аюуш, Утас: [REDACTED].</p> <p>2012-2018 онд Хууль сахиулахын Их сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимд багш. Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, VIII хороо, Хилчний гудамж, ш/х-210332, холбоо барих [REDACTED]. / Доктор, профессор, цагдаагийн хурандаа Т.Оюунчимэг, [REDACTED], Доктор, профессор, цагдаагийн хурандаа Ш.Ариунбилэг, Доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа Ж.Нямдулам, [REDACTED], Ахлах багш, доктор, цагдаагийн дэд хурандаа Д.Бадамцэцэг, [REDACTED], Доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа С.Гантулга, Утас: [REDACTED].</p> <p>3. 2011-2012 онд Дотоод хэргийн их сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимд багш. Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, VIII хороо, Хилчний гудамж, ш/х-210332, холбоо барих [REDACTED]. /С.Оюунчимэг, Ч.Мягмарбаяр, Б.Атарцэцэг/</p> <p>4. 2009-2011 онд Цагдаагийн Академийн Иргэний эрх зүйн тэнхимд багш. Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, VIII хороо, Хилчний гудамж, ш/х-210332, холбоо барих утас: [REDACTED]. /А.Отгонбаатар, О.Отгонтуяа, Н.Манлайбаатар, Доктор, дэд профессор С.Энхбаяр, Утас: 88110387, Доктор, цагдаагийн хошууч Г.Батжаргал, [REDACTED]/</p> <p>5. 2012 оноос хойш Монголын хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоонд хуульч-өмгөөлөгчөөр ажиллаж байна.</p> <p>6. 2008-2009 онд Хэнтий Аймгийн цагдаагийн газарт төлөөлөгч.</p>
	<p><b>Эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажил</b> Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ингэхдээ ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</p> <p>Эрх зүйчээс бусад мэргэжлээр ажиллаж байгаагүй.</p>
<p><b>3.4</b></p>	<p><b>Хууль зүйн өндөр мэргэшил</b> Хүсэлт гарагчийг хууль зүйн өндөр мэргэшилтэй /хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай, мэргэжлийн өндөр ёс зүйтэй/ гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлох бөгөөд үйл ажиллагаа тус бүрийг явуулсныг нотлох баримтыг хавсаргана. Ийм үйл ажиллагаа тус бүрийн талаар дараах мэдээллийг заавал бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>-үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;</li> <li>-үйл ажиллагааны гол агуулга;</li> <li>-үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;</li> <li>-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;</li> <li>-тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан гурваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн</li> </ul>

хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;

-хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай Монгол Улсын хуульд зааснаар өмгөөлөл, хууль зүйн зөвлөгөө, мэргэжлийн туслалцааг тодорхой Иргэн, Гэр бүл, Хөдөлмөр, Захиргааны маргааны чиглэлээр дагнан 2012 оноос хойш өнөөг хүртэл хуульчийн мэргэжлийн болон өмгөөллийн үйл ажиллагааг хийж байна. Иргэний, Гэр бүлийн, Хөдөлмөрийн, Захиргааны олон хэрэг, маргаанд үйлчлүүлэгчийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг амжилттай хамгаалж, өмгөөлөл, хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлсэн. 2014 оноос хойш төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө, туслалцааг үзүүлж, пробоно үйлчилгээг тогтмол үзүүлж байгаа. **Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоонд хуульч, өмгөөлөгчөөр Өмгөөллийн үйлчилгээ (2012 оноос), **Үйл ажиллагааны гол агуулга:** Иргэн, гэр бүл, хөдөлмөр, захиргааны хэрэгт хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн туслалцаа үзүүлсэн. **Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:** Олон арван хэрэг маргаанд хууль зүйн туслалцаа, зөвлөгөө өгч, эрхийг нь шүүхэд төлөөлж хамгаалсан. **Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл:** Өмгөөллийн байгууллагын удирдлага. Хаяг: Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, 13-р хороолол Г.Чагдаржавын гудамж 32/2, "Сав плаза" 18-1804 тоот, 17-1702 тоот, Утас: [7012-6861](tel:7012-6861) [info@umquulul.mn](mailto:info@umquulul.mn). **Хамтран ажилласан хүмүүсийн нэр, холбоо барих мэдээлэл:** Үйлчлүүлэгчид, хуульчид, өмгөөлөгчид.
2. Цагдаагийн Академи, Хууль сахиулахын их сургууль, Дотоод хэргийн их сургуулиудад 2009-2019 оныг хүртэл Иргэний эрх зүй, Гэр бүлийн эрх зүй, Эрх зүйн онолы, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн чиглэлээр багшилж Иргэн, Гэр бүлийн чиглэлээр мэргэшин судалгаа хийж, бүтээл туурвиж байсан. **Үйл ажиллагааны гол агуулга:** Иргэний эрх зүй, Гэр бүлийн эрх зүй, Эрх зүйн онолын чиглэлээр бакалавр, магистрын түвшинд лекц уншиж, сургалт зохион байгуулсан. **Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:** Олон тооны мэргэжлийн боловсон хүчин бэлтгэж, хичээл заасан оюутнууд хууль зүйн салбарт амжилттай ажиллаж байна. **Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл:** Дотоод хэргийн их сургуулийн захиргаа, Хаяг: Баянзүрх дүүрэг, VIII хороо Хилчний гудамж, ш/х - 210332, Улаанбаатар хот, Утас: (976)-[info@uia.gov.mn](mailto:info@uia.gov.mn) **Хамтран ажилласан хүмүүсийн нэр, холбоо барих мэдээлэл:** Доктор, профессор, цагдаагийн хурандаа Т.Оюунчимэг, [REDACTED], Доктор, профессор, цагдаагийн хурандаа Ш.Ариунбилэг, Доктор, дэд профессор С.Энхбаяр, [REDACTED], Доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа Ж.Нямдулам, [REDACTED], Ахлах багш, доктор, цагдаагийн дэд хурандаа Д.Бадамцэцэг, [REDACTED], Доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа [REDACTED].
3. Байгууллагын дотоод журам, дүрэм, кодыг Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсронгуй болгох ажлын хэсэгт 2009-2018 он хүртэл ажиллаж ирсэн.
4. 2015 онд “Эрх зүйн процесс: Онол, практик” ЭШХ-ыг Монголын хуулийн байгууллагуудын хүрээнд Тэнхимийн хамт олонтойгоо зохион байгуулан ажилласан.
5. “Нийтийн эрх зүйн хэм хэмжээний хэрэглээ, анхаарах зарим асуудал” онол практикийн бага хурлыг 2014 онд Их сургуулийнхаа хамт олонтой хамтарч зохион байгуулсан.
6. “Хууль сахиулах байгууллагуудын захиргааны үйл ажиллагаа ба эрх зүйн

	<p>шинэтгэлийн зарим асуудал” эрдэм шинжилгээний бага хурлыг 2013 онд тэнхимийн хамт олонтой хамтарч зохион байгуулсан.</p> <p>7. Захиргааны хяналт: үр нөлөө, боловсронгуй болгох зарим асуудал эрдэм шинжилгээний бага хурлыг 2011 онд тус тус хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулж байсан.</p> <p>8. 2010 онд Цагдаагийн Академийн магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн шийдвэрээр “Шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах нь” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. Удирдагч: Хууль зүйн дозтор, профессор, цагдаагийн хурандаа Н.Гантулга. Одоо канад улсад амьдардаг.</p> <p>9. Хууль сахиулахын их сургуулийн Эрх зүйч мэргэжлийн профессорын багийн профессороор 2014-2018 он хүртэл ажиллаж байсан.</p> <p>10. ХЗДХЯ, Цагдаагийн Ерөнхий Газар, Цагдаагийн академийг хамтарсан “Иргэн, эдийн засгийн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах тэдгээрийн хооронд уялдаа, холбоог сайжруулах” төслийн ажлын хэсэгт 2010 онд ажиллаж байсан.</p> <p>11. 2004-2018 онд Монголын Залуучуудын холбоо, Залуу удирдагч сан, “Улсын их хурал”-ын даргын ивээл дор зохион байгуулагддаг “Эврика” багш, оюутны Эрдэм шинжилгээний их хурал, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч Б.Чимидийн нэрэмжит ЭШХ, Гавьяат хуульч Ж.Авхиагийн нэрэмжит ЭШХ зэрэг бүхий л төрлийн ЭШХ, мэтгэлцээний тэмцээнүүдэд оролцож байсан. <b>Жич:</b> Бичиж туурвисан ном сурах бичиг, илтгэл, эрдэм шинжилгээний өгүүллүүд энэхүү хэсэгт бичигдэхээр давхцаж байгаа учир бүтээлийн жагсаалтад дэлгэрэнгүй оруулав, мөн нотлох баримтуудыг бүгдийг нь хавсаргав.</p>
<p><b>3.5</b></p>	<p><b>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</b>  Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн эсхүл хүний эрхийн чиглэлээр ажилладаг бусад холбоо, байгууллагад гишүүн бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар нэрлэн бичиж, гишүүнчлэл тус бүрийг нотлох баримтыг хавсаргана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүргийн нэр, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Монголын Өмгөөлөгчдийн холбоо-2020 оноос</li> <li>2. Монголын Хуульчдын холбоо-2013 оноос</li> <li>3. Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хорооны удирдах зөвлөлийн гишүүн-2019 оноос</li> <li>4. Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хорооны гишүүн-2016 оноос</li> <li>5. Монголын Хуульчдын холбооны хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх асуудал эрхэлсэн хорооны гишүүн-2016 оноос</li> <li>6. Монголын Хуульчдын холбооны Өмгөөлөгчдийн хороонд-2016 оноос</li> </ol>
<p><b>3.6</b></p>	<p><b>Байгаа бол хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</b>  -Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ.</p>

Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.

-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.

**Жич:** Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.

**А. Ном, гарын авлага**

1. Хүнийг захиалгаар алах гэмт хэргийгч гүйцэтгэх ажлын аргаар илрүүлэх зарим асуудал., УБ 2008 он. /Дипломын ажил/.
2. Шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах нь., УБ 2010 он /Хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан дипломын ажил/
3. Шүүх хуралдааны аюулгүй байдал., УБ 2010 он., /гарын авлага 8хх/
4. Монгол Улсын Гэр бүлийн эрх зүй.. УБ 2014 он., /гарын авлага 11.5хх/
5. Цагдаагийн байгууллагаас захиргааны зөрчилтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа /онол, практикийн асуудлууд УБ 2015 он 280 хх

**Б. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл**

6. Сонгуулийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал., УБ 2005 он., Эрдэм шинжилгээний илтгэл.
7. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний зөрчилдөөний зарим асуудал., УБ 2007 он., Эрдэм шинжилгээний илтгэл.
8. Эх нь нярай хүүхдээ алах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж, зүйлчлэлийн зарим асуудал., УБ 2006 он., Эрдэм шинжилгээний илтгэл.
9. Гэрээт харуул хамгаалалтын эрх зүйн зохицуулалт, практикийн зарим асуудал., УБ 2007 он. Эрдэм шинжилгээний илтгэл.
10. Эрүүгийн хуулийн алгасуулан иш татсан /бланкет/ хэм хэмжээний хууль зүйн учир холбогдол., УБ 2006 он., Монгол Улсын Хууль зүйн салбарын 2006 оны Эрүүгийн эрх зүйн салбарын шилдэг илтгэл.
- 11.Терроризм түүнтэй тэмцэх асуудал., УБ 2008 он., Эрдэм шинжилгээний илтгэл.
- 12.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааны онол, арга зүйн зарим асуудал., УБ 2006 он., Эрдэм шинжилгээний илтгэл.
- 13.Хууль зүйн практикийн зарим асуудал /Өршөөл үзүүлэх тухай хуулийн жишээн дээр/, УБ
- 14.Захиргааны эрх зүйн шинжлэх ухааны онолууд тэдгээрийн агуулга, ач холбогдол., УБ 2004 он., Эрдэм шинжилгээний илтгэл.
- 15.Хүнийг алах гэмт хэргийн ангиллын зарим асуудал., УБ 2008 он., Эрдэм шинжилгээний илтгэл.
- 16.Хүнийг захиалгаар гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж, зүйлчлэлийн зарим асуудал., УБ 2008 он., Эрдэм шинжилгээний илтгэл.
- 17.Шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах нь., УБ 2009 он., Эрдэм шинжилгээний илтгэл.
- 18.Шүүх хуралдааны аюулгүй байдал ба шүүх хуралдаан нээлттэй явуулах зарчмын хууль зүйн харилцан хамаарлын зарим асуудал., УБ 2010 он, Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Б.Чимидийн нэрэмжит ЭШХ-ын 3 дугаар байрын шагналт илтгэл, мөн Хууль дээдлэх ёс сэтгүүлийн 2010 оны №3 дугаар, Үндсэн хууль ба эрх зүйт ёс-2 дугаарт тус тус нийтлэгдсэн.
- 19.Шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангахад анхаарах зарим асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ., УБ 2010 он., “Эврика-2010” багш, оюутны ЭШХ-ын удаах байрын шагналт илтгэл.
- 20.Шүүх эрх мэдлийн талаархи үндсэн хуулийн болон бусад хуулийн зарим хэм хэмжээг харьцуулан судлах нь., УБ 2011 он., “Эврика-2011” багш,

	<p>оюутны ЭШХ-ын удаах байрын шагналт илтгэл.</p> <p>21. Шүүх хуралдаан нээлттэй явуулах зарчмын хууль зүйн учир холбогдол (Эрүүгийн шүүн таслах ажиллагааны жишээн дээр)., УБ 2012 он., Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүлийн 2012 оны №1 дугаарт нийтлэгдсэн ЭШ-ийн өгүүлэл.</p> <p>22. Америкийн нэгдсэн улс дахь хуульч мэргэжлийн бүтэц болон хууль зүйн боловсролын тогтолцоо., УБ 2012 он, Дотоод хэргийн Их сургуулийн цагдаагийн сургуулиас эрхлэн гаргадаг “Цагдаа судлал” сэтгүүлийн 2012 оны №1 дүгээр дугаарт нийтлэгдсэн ЭШ-ийн өгүүлэл.</p> <p>23. Иргэний хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд тулгамдаж буй зарим асуудал., УБ 2015 он., “Эрх зүйн процесс: Онол, практик” ЭШХ-д хэлэлцүүлсэн илтгэл.</p> <p><b>В. Удирдсан илтгэл</b></p> <p>24. “Богд хаант Монгол Улсын үеийн төрийн бэлгэдэл: агуулга мөн чанар”</p> <p>25. “Үндсэн эрхийг гадаадын зарим орны Үндсэн хуулийн хэмжээнд харьцуулан судлах нь</p> <p>26. “Ялгуун баатар Лаварын Сумъяа /намтар судлал/”</p> <p>27. “Орон сууц хөлслөх гэрээний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал”</p> <p>28. “Амрах эрх түүний хууль зүйн мөн чанар”</p> <p>29. “Архидалт ба үндэсний аюулгүй байдал”</p> <p>30. “Гэрээт харуул хамгаалалтын албаны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал”,</p> <p>31. “Сонгуулийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал”</p> <p><b>Г. Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага</b></p> <p>32. 2020 оны 06 дугаар сарын 06-ны өдөр “Mongol HD” телевизийн өглөө хөтөлбөрт “Цахим орчинд бусдыг гүтгэх, доромжлох үйл ажиллагаанаас болж бусдад учирч буй сэтгэл санааны хохирлыг хэрхэн арилгах вэ” ярилцлага.</p>
--	--

**Хавсралт:**

Нэр дэвших тухай хүсэлтэд журмын 5.1-д заасан дараах баримт бичгийг хавсаргана:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;
- Эрх зүйн бакалаврын, эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;
- Хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдгийг нотлох харуулсан үйл ажиллагааны талаарх баримт;
- Эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт;
- Хүсэлт гаргагчийн талаарх тодорхойлолт /гурваас доошгүй/;
- Энэхүү загварт заасан баримт бичиг;
- Холбогдох бусад баримт.

**Хүсэлт гаргагч:**

Эцэг/эхийн нэр: Базаррагчаа

Өөрийн нэр: Даваажав

Гарын үсэг:

Он, сар, өдөр: 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр